

## **“ЭРДМИЙН ЧУУЛГАН-2019” ПРОФЕССОР, БАГШ, СУДЛААЧДЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ**

**1. Зорилго:** ШУТИС-ийн профессор, багш, судлаачдын гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хэлэлцэх, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцоход оршино.

**2. Хамрах хүрээ:** ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, харьяа болон бүрэлдэхүүний хүрээлэн, эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн профессор, багш, залуу судлаач, эрдэм шинжилгээний ажилтан.

### **3. Эрдэм шинжилгээний хурлын чиглэл:**

- Техник-технологи
- Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухаан
- Нийгэм, хүмүүнлэгийн ухаан

### **4. Нийтлэг шаардлага:**

- 2017, 2018 онуудад гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн байх;
- Урьд нь хэвлэн нийтлэгдээгүй бүтээл байх;
- Сэдвийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон, баримт нотолгоонд тулгуурласан, шинэлэг санаа, практик ач холбогдол, түүний хэрэгцээг тодорхойлсон дүгнэлттэй байх;
- Бүтээлд гадаад, дотоодын эх сурвалж /12-оос доошгүй эшлэл хэрэглэх/-ийг ашигласан байх, бусдын бүтээлийг ашиглахдаа эх сурвалжийг заавал дурдсан байх;
- I шатанд хэлэлцүүлж шалгарсан бүтээл байх /захирлын албан бичгээр баталгаажуулах/;
- Тухайн салбарын 2-оос доошгүй эрдэмтдээс шүүмж авсан байх /II шатанд оролцогчдын хувьд/;
- ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих зааврыг баримтална.  
Холбоос: <http://www.must.edu.mn/static/uploads/files/hawsralt1-2.pdf>

### **5. Хугацаа, үе шат:**

**I шат:** Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгүүд *2019 оны 2 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд* профессор, багш, судлаачдын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.

**II шат:** Профессор, багш, судлаачдын “Эрдмийн чуулган - 2019” эрдэм шинжилгээний нэгдсэн хурал *2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 10 цагаас* ШУТТНСангийн E-604, 405, Эрдмийн зөвлөлийн өрөө I-203 тоот хурлын танхимд тус тус болно.

Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн тус бүрээс II шатанд оролцох 3 хүртэлх шилдэг өгүүллийг *2019 оны 2 дугаар сарын 19-ний дотор* Эрдэм шинжилгээ, инновацийн газарт хэвлэмэл болон файлаар [research@must.edu.mn](mailto:research@must.edu.mn) цахим хаягаар албан бичгийн хамт ирүүлнэ.

## **6. Эрдэм шинжилгээний хурлын шагнал, урамшуулал:**

- Техник-технологи:

I байр – Батламж, 1 сая төг  
II байр – Батламж, 700 мян.төг  
III байр – Батламж, 500 мян.төг

- Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухаан:

I байр - Батламж, 1 сая.төг  
II байр – Батламж, 700 мян.төг  
III байр – Батламж, 500 мян.төг

- Нийгэм, хүмүүнлэгийн ухаан:

I байр – Батламж, 1 сая.төг  
II байр – Батламж, 700 мян.төг

## **7. Бүтээлийг нийтэд түгээн дэлгэрүүлэх:**

Хуралд хэлэлцүүлсэн өгүүллийн эмхэтгэлийг Эрдэм шинжилгээ, инновацийн газраас эрхлэн гаргаж, олны хүртээл болгох, таниулах ажлыг зохион байгуулна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ГАЗАР